


БАТЛАВ.СУРГАЛТ, ОЮУТНЫ ХӨГЖИЛ ЭРХЭЛСЭН ПРОРЕКТОР

Н.ЭРДЭНЭХҮҮ



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2024-2025 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХАВРЫН УЛИРЛЫН “ЭРДМИЙН БАЯР”
ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ**

Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь Монголын үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн эх орондоо сургаж бэлтгэх ажлыг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1959 оны тогтоолоор эхлүүлж 6 аравны түүхийг бүтээж яваа Монголын ууган их сургуулийн нэг билээ.

2024-2025 оны хичээлийн жилд бакалаврын 94, магистрын 56 дэх удаагийн “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг тэмдэглэн өнгөрүүлэх гэж байна.

Арга хэмжээний зорилго:

ШУТИС-ийн 2024-2025 оны хичээлийн жилийн хаврын улиралд төгсөж буй нийт суралцагчдад “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааг ёслол төгөлдөр зохион байгуулахад оршино.

Хамрах хүрээ:

ШУТИС-ийн эрдэмтэн багш, ажилтан, нийт төгсөгчид, гэр бүл, найз нөхөд оролцоно.

Хэзээ: 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр 10:00-17:00 цагт

Хаана: “Соёлын төв өргөө”-нд болно.

Төгсөгчдийн тоо:

- Доктор: 3
- Магистр: 402
- Бакалавр: 2134
- Нийт: 2539

Арга хэмжээний зохион байгуулалт:

- “Эрдмийн баяр”-ын үйл ажиллагаанд Улаанбаатар хотод нийт 2238 гаруй төгсөгчийг 2 хэсэгт хуваан диплом гардуулах бөгөөд хэсэг бүрд нийт 1000-1100 төгсөгч хамрагдахаар зохион байгуулна. Дархан, Эрдэнэтийн сургууль өөрийн хуваарийн дагуу тусдаа гардуулна.
- Төгсөгчдийн баярын үйл ажиллагаанд нийт төгсөгчид, ШУТИС-ийн удирдлагууд, эрдэмтэн багш нар, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд дараах хуваарийн дагуу оролцоно. Үүнд:

№	Үйл ажиллагаа	Хамрагдах төгсөгчийн тоо	Огноо	Цаг	Хэсгийн дугаар	Оролцох удирдлагууд
1	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	446	2025.06.16	10:00-12:30	I хэсэг	Т.Намнан Н.Эрдэнэхүү Д.Цолмонбаатар В.Өлзийбаяр Р.Бадмаанямбуу Л.Баяр-Эрдэнэ Г.Баттүвшин Н.Ганзориг Н.Пүрэвдорж
	Менежментийн сургууль	185				
	Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль	284				
	Механик инженер, тээврийн сургууль	218				
Нийт		1,133				
2	Геологи уул, уурхайн сургууль	296	2025.06.16	14:00-16:30	II хэсэг	Т.Намнан Н.Эрдэнэхүү Д.Цолмонбаатар В.Өлзийбаяр Р.Бадмаанямбуу К.Хавалболот Бя.Бат-Эрдэнэ Б.Нарантуяа Я.Төгөлдөр Б.Тунгалагтамир Ц.Энхбаатар Д.Ганбат Д.Дулмаа
	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль	271				
	Барилга архитектурын сургууль	386				
	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	71				
	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	61				
	Гадаад хэлний сургууль	18				
	Нээлттэй боловсролын хүрээлэн	2				
	ШУТИС-Коосэн технологийн коллеж	28				
Нийт		1,113				
ДаТС			2025.06.16	10:00-11:30	Орон нутаг дахь сургуульд тусдаа гардуулалт хийгдэнэ.	
ЭЦДС			2025.06.16	10:00-11:30		

Анхааруулга:

- “Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагаанд оролцож буй нийт төгсөгчид 30 минутын өмнө хүрэлцэн ирж суудлаа эзэлнэ.
- Бүх түвшний төгсөгчид эрдмийн баярын ёслолын өмсгөлөө өмссөн байна.

НЭГ: “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

“Эрдмийн баяр” төгсөлтийн ёслолын ажиллагааны заал, тайзыг урьдчилан бэлтгэж ёслол хүндэтгэлийн үйл ажиллагааг хэсэгчлэн зохион байгуулна.

2025.06.16-ны өдрийн 10:00-12:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр

I хэсэг /МХТС, МС, ХХҮДС, МИТС/

09:30-10:00 Соёлын төв өргөөний хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх

10:00-10:03 Нээлт Хөтлөгч

10:03-10:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.

10:05-10:15 ШУТИС-ийн Ректор доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.

10:15-10:25 ШУТИС-ийн удирдах зөвлөлийн дарга Д.Гантулга мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.

10:25-10:28 Төрийн дуулал эгшиглэнэ.

10:28-10:35 Төгсөгчдөд диплом олгох Ректорын тушаалыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.

10:35-12:00 Диплом гардуулах үйл ажиллагаа: Диплом, гардуулах зочдыг урих
(Төгсөгчдийн нэрсийг дуудаж, дипломыг хүндэтгэлтэйгээр гардуулна)

- Докторын зэрэгтэй төгсөгчид
- Магистрын зэрэгтэй төгсөгчид
- Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- Шилдэг, тэргүүний төгсөгчдөд шагнал гардуулах ажиллагаа

12:00-12:05 Профессорын мэндчилгээ /МИТС/

12:05-12:10 Магистрын зэрэг хүртсэн төгсөгч үг хэлнэ. /МС/

12:10-12:15 ШУТИС-ийн бакалаврын шилдэг төгсөгч үг хэлнэ. /МХТС/

12:15-12:20 Ая дууны мэндчилгээ дэвшүүлнэ.

12:20-12:25 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол

12:25-12:30 Малгай шидэлтийн баяр

12:30-12:35 Ёслолын ажиллагааны хаалт

12:35-12:45 Заал чөлөөлөх /Заагдсан дурсгалын зураг татуулах хэсэг рүү явах/ 2-р хэсэг суудлаа эзлэх, сургалтын албаны ажилтнууд диплом байрлуулах

2025.06.16-ны өдрийн 14:00-16:30 цагийн арга хэмжээний хөтөлбөр

II хэсэг /ЭХИС, ГУУС, БАС, НХС, ХШУС, ГХС, НБТ, КТК /

13:30-14:00 Соёлын төв өргөөний хурлын танхимд төгсөгчид суудлаа эзлэх

14:00-14:03 Нээлт Хөтлөгч

14:03-14:05 ШУТИС-ийн удирдлагууд, хүндэт зочдыг танилцуулна.

14:05-14:15 ШУТИС-ийн Ректор доктор, профессор Т.Намнан мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.

14:15-14:25 ШУТИС-ийн удирдах зөвлөлийн дарга Д.Гантулга мэндчилгээ дэвшүүлж үг хэлнэ.

14:25-14:27 Төрийн дуулал эгшиглэнэ.

14:27-14:35 Төгсөгчдөд диплом олгох Ректорын тушаалыг Сургалтын бодлого, хөтөлбөрийн албаны дарга доктор, М.Эрдэнэтуяа уншиж танилцуулна.

14:35-15:55 Диплом гардуулах үйл ажиллагаа: Диплом гардуулах зочдыг урих
(Төгсөгчдийн нэрсийг дуудаж, дипломыг хүндэтгэлтэйгээр гардуулна)

- Магистрын зэрэгтэй төгсөгчид
- Бакалаврын зэрэгтэй төгсөгчид
- Шилдэг, тэргүүний төгсөгчдөд шагнал гардуулах ажиллагаа

15:55-16:00 Профессорын мэндчилгээ /ГУУС/

15:55-16:05 Магистрын мэндчилгээ /БАС/

16:05-16:10 ШУТИС-ийн бакалаврын шилдэг төгсөгч үг хэлнэ. /ЭХИС/

16:10-16:15 Ая дууны мэндчилгээ дэвшүүлнэ.

16:15-16:20 Төгсөгчдийн тангараг өргөх ёслол

16:20-16:25 Малгай шидэлтийн баяр

16:25-16:30 Ёслолын ажиллагааны хаалт

16:30-17:00 Заал чөлөөлөх /Заагдсан дурсгалын зураг татуулах хэсэг рүү явах/

ХОЁР. “ЭРДМИЙН БАЯР” ТӨГСӨЛТИЙН ЁСЛОЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албуудад өгөх зөвлөмж

- ✓ Бүрэлдэхүүн сургуулиудын сургалт, чанарын алба, төгсөлтийн нарийн бичгийн дарга, оюутны үйлчилгээний алба төгсөлтийн ёслолын ажиллагааг хамтран зохион байгуулна.
- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагаанд дараах дарааллын дагуу нэрсийг дуудаж дипломыг гардуулна. /Доктор, магистрын шилдэг, магистр, бакалаврын шилдэг, тэргүүний, бакалавр/
- ✓ Хуваарийн дагуу нэг хэсэгт багтсан бүрэлдэхүүн сургууль тус бүр диплом гардан авах төгсөгчдийн нэрсийг төгсөлтийн арга хэмжээг хөтлөх хөтлөгчид өгч нэрсийг зарлуулан дипломыг гардуулна.
- ✓ Төгсөлтийн хуваарь, дуудах нэрсийн дарааллын дагуу төгсөгчдийн бүх дипломыг бэлтгэн бэлэн болгосон байна.
- ✓ Төгсөгчдөд энгэрийн тэмдэг /ромбо/-г урьдчилан тарааж зүүлгэсэн байна.
- ✓ Төгсөгчдийн суудал хуваарилалтыг нарийвчилсан тоо тодорхой болсны дараа СА-нд хүргүүлж, хариуцсан салбар, тэнхимийн багш нарт хүлээлгэн өгч төгсөгчдөд мэдээлэл хүргүүлсэн байна.
- ✓ Үг хэлэх профессор багш, төгсөгчийн бэлтгэл ажлыг хангуулж хөтлөгчид нэрсийг хүргүүлсэн байна.
- ✓ Диплом гардуулах ёслолын ажиллагаанд мэндчилгээ дэвшүүлэх профессор, доктор, магистр, бакалаврын шилдэг төгсөгч нарын нэр, эрдмийн зэрэг цолыг tsogzolmaa@must.edu.mn хаягаар 2025 оны 06 дугаар сарын 13-ны дотор ирүүлсэн байна.
- ✓ Төгсөлтийн нарийн бичгийг зохион байгуулалтад оролцуулан төгсөгч оюутнуудыг хурлын зааланд оруулах, арга хэмжээ дуустал заалнаас гаргахгүй эмх цэгцтэй байлгах, төгсөгчдөд тайлбар зөвлөмж хүргэх.
- ✓ Хоцорсон, тухайн ээлжид оролцоогүй оюутны дипломыг буцаан авч ёслолын бус цагаар гардуулна.
- ✓ Тусдаа байртай сургуулиуд хавсралт 1.т заасны дагуу 1,2-р байруудад хуваарилагдсан өрөөнүүдэд хувцсаа солино.

Бүрэлдэхүүн сургуулийн төгсөлтийн нарийн бичгийн дарга нарт өгөх зөвлөмж:

- ✓ Тэнхимийн оюутнуудыг ёслолын ажиллагааны хуваарийн дагуу цагт нь бүртгэж оруулна. Арга хэмжээ эхэлсэн цагаас дуусах хүртэл танхимд суулгах.
- ✓ Үг хэлэх сургуулийн төлөөлөл профессор багш, төгсөгч нарт үйл ажиллагааны хөтөлбөрийг урьдчилан танилцуулж, үгийг бэлдүүлж үйл ажиллагаанд оролцуулна.

Төгсөгчдөд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөлтийн ёслолын үйл ажиллагаа 2025 оны 06 дүгээр сарын 16-ны өдрийн өглөөний 10:00, 14:00 цагаас тус тус хуваарийн дагуу зохион байгуулагдана.
- ✓ Төгсөлтийн ёслолын ажиллагаанд нийт төгсөгчид хавсралтад заасан хуваарийн дагуу 2 хэсэгт хуваагдаж диплом гардаж авна.
- ✓ Төгсөлтийн ёслолын арга хэмжээг 2 цаг 30 минутын хугацаанд зохион байгуулагдах бөгөөд дараагийн хэсэг эхлэхээс 60 минутын өмнө завсарлана. /Хуваарьт хөтөлбөрийн дагуу/
- ✓ Төгсөгчид хувцас солих, ёслолын арга хэмжээнд оролцох бэлтгэлээ хангах зориулалт бүхий анги танхимын дугаарыг сургалтын албаны мэргэжилтнээс тодруулсан байна.
- ✓ Төгсөгчид хуваарьт цагаас 1 цагийн өмнө ирж, арга хэмжээ эхлэхээс 30 минутын өмнө суудлаа эзэлсэн байна.
- ✓ Нийт төгсөгчид Соёлын төв өргөөнд төгсөгчийн нарийн бичгээс өгсөн өөрийн дугаарлалт бүхий суудалд суух бөгөөд гардуулах удирдлагуудын оноосон дугаарын дагуу эгнээ тус бүрээр дипломоо гардан авна.
- ✓ Нийт төгсөгчдөд хэсэг тус бүрийн тухайлсан хөтөлбөр, диплом гардаж авах нэрсийн жагсаалтын хамтаар хүргэнэ.
- ✓ Энгэрийн тэмдэг урьдчилан зүүсэн байна.
- ✓ Диплом гардуулах үеийн дурсгалын зургийг [Drive.google.com](https://drive.google.com) холбоосоор нээлттэй байршуулна.
- ✓ Төгсөгчид арга хэмжээ дууссаны дараа тухайлан засаж бэлтгэсэн газруудад дурсгалын зургууд татуулна.

Эцэг, эхчүүдэд өгөх зөвлөмж:

- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн бэлтгэсэн зориулалтын талбайд дурсгалын зураг татуулж болно. /Хүснэгт 4-т заасан байрлалуудад/
- ✓ Төгсөгчдийн ар гэрийнхэн ШУТИС-ийн пэйж хуудсаар шууд дамжуулалтыг хүлээн авч үзэх боломжтой.
- ✓ Эцэг, эхчүүдийг арга хэмжээ зохион байгуулагдаж буй хурлын танхимд оруулахгүй болохыг анхаарна уу.

Хувцас солих өрөө

Хүснэгт.2

№	Сургуулийн нэр	Хичээлийн байр	Өрөөний дугаар, анги	Хариуцах эзэн
1	Механик инженер, тээврийн сургууль	1-р байр	107 тоот	ХХҮДС, ОУА
2	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	2- байр	422 тоот	ЭХС, ОУА
3	Нийгэм, хүмүүнлэгийн сургууль	2-р байр	419 тоот	ЭХС, ОУА
4	Менежментийн сургууль	1-р байр	112 тоот	ХХҮДС, ОУА
5	Барилга, архитектурын сургууль	Төгсөгчид сургалтын албанаас тодруулна.		
6	Гадаад хэлний сургууль			
7	Геологи, уул уурхайн сургууль			
8	Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургууль			
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль			
10	Эрчим хүчний инженерчлэлийн сургууль			

Дурсгалын гэрэл зураг татуулах хэсэг

Хүснэгт.3

№	Байршил	Зураг	Хугацаа	Хариуцах эзэн
1	Соёлын төв өргөөний доторх төв хаалганы хэсэг		2025.06.16	ОУА

Төгсөгчдөд зориулсан зураг татуулах хэсэг

Хүснэгт.4

№	Байршил	Зураг	Хугацаа	Хариуцах эзэн
1	Соёлын төв өргөөний төв хаалганы гаднах хэсэг		2025.06.16	ОУА

Эцэг, эх, төгсөгчдөд зориулсан зураг татуулах хэсэг